

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангал сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2025/069/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2023 он	Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга, тэргүүлэх аудиторовын албан тушаалын үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол Утас: 70342580 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу,



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.22

№

118

танай

ны №

т

ХАНГАЛ СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА
Л.САЙНГЭРЭЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангал сумын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хангал сумын ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн нийцүүлэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 50.2 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудлууд

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

632502174

Хангал сумын Засаг даргын тамгын газар нь 1 хөтөлбөр 7 зориулалт арга хэмжээний хүрээнд 1,308,435.1 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 1,263,178.4 мянган төгрөгийг зарцуулж 45,256.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ



Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	182,680.4	202,289.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,922,741.9	2,445,292.6
	Нийт хөрөнгийн дүн	2,105,422.2	2,647,582.3
	Нийт өр төлбөрийн дүн	-	482.3
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,105,422.2	2,647,099.9
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,105,422.2	2,647,582.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,845,370.7	1,954,007.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,033,939.6	1,411,392.7
	Үйл ажиллагааны үр дүн	811,431.1	542,614.3
	Үйл ажиллагааны бус үр дүн	962.0	(936.6)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	812,393.1	541,677.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,293,029.1	2,105,422.2
	Тайлант оны үр дүн	812,393.1	541,677.7
	Эцсийн үлдэгдэл	2,105,422.2	2,647,099.9
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	931,774.1	1,343,211.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	887,994.1	1,338,093.4
	Үйл ажиллагааны ЦМГ	43,780.0	5,118.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(43,780.0)	(5,118.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	(0.0)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	1,263,178.4
	Урсгал зардал	-	1,263,178.4
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	1,263,178.4
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав: Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хангал сумын ЗДТГ нь эдийн засгийн бие даасан байдлаа нэмэгдүүлж, иргэн бүрд тэгш үйлчилгээг бүтээлч сэтгэлгээтэй, чадварлаг, хариуцлагатай, мэдэл, чадварт суурилан түргэн шуурхай хүргэж, мэргэшсэн тогтвортой захиргааны байгууллага байх эрхэм зорилгын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Сум орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийг төлөвлөлт, хөтөлбөр төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлэн дүгнэх, бодлогын удирдамжаар хангах
- Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон тамгын газрын албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах
- Нутгийн захиргааны байгууллагыг үйл ажиллагаа үр нөлөөтэй, үр ашигтай явуулахад чиглүүлэн удирдахад нь засаг даргад бүх талын дэмжлэг үзүүлэх
- Аймаг сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засаг нийгмийг хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд Засаг даргын Тамгын Газрын албадын үйл ажиллагааны уялдааг хангах, шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээгээр цаг тухайд нь хангах

Дөрөв: Аудитын ирлүүлэлт

Аудитаар нийт 22,500.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс тухайн алдааг аудитын явцад алдааг залруулж

Аудитаар нийт 7,076.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 3,188.9 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 3,888.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Төлбөрийн акт

1.Өмнөх оны бараа материалын тооллогыг хийж үлдэгдлийг тоолж баталгаажуулсан байхад тайлант онд нийт 1,686.0 мянган төгрөгийн дансны үнэтэй 2023 оны малын зарлагыг тушаалаар зарлагдсан нь НББ-ийн тухай хуулийн 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.6-д заасныг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд төлбөрийн акт тогтлоо.

2. Анхан шатны баримтаар нотлогдоогүй 638.7 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.7, 20.2.4-заасан заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3. Шинэ жилийн арга хэмжээнд зориулан 864.2 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл, хуулиар хориглосон ундаа худалдан авахад зарцуулж Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5, 15.1.7-д заасныг зөрчсөн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

1. Сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/01 дүгээр захирамжаар Засаг даргын газрын бүтэц орон тоог батлахдаа бүтэц орон тооны хязгаарыг хэтрүүлэн баталж гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтны 0.5 орон тоог баталж нийт 2,838.0 мянган төгрөгийн ажил хавсран ажилласны нэмэгдэл хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.3, 16.5.5-д, Засгийн газрын тогтоол 2018 оны 08 дугаар 22-ны өдрийн 267 тоот тогтоолын 4-д заасныг зөрчсөн зөрчилд таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл, арга хэмжээг зохион байгуулсан үнэлгээний хорооны гишүүдэд 1,686.0 мянган төгрөгийн урамшууллыг тендерийн бичиг баримтын орлогоос олгосон нь Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/254 дүгээр тушаалаар баталсан "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам"-ын 3.7-д заасан заалттай нийцээгүй зөрчилд төслөн зогсоох албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд өмнөх оны тайлангийн үзүүлэлтийг илэрхийлээгүй нь санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр А/229 дугаар тушаал

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа холбогдох журмыг бүрэн баримтлан зарцуулаагүй байгаа нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3, 4 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авсан үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн аудитын ангилал батламж мэдэгдлийн хангахгүй байна.	1	25,200.0	1	25,200.0			1	25,200.0				
Дүн	1	25,200.0	1	25,200.0	-	-	1	25,200.0	-	-	-	

**Санхүүгийн тайлангийн аудитын
зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд өмнөх оны тайлангийн үзүүлэлтийг илэрхийлээгүй нь санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1						1					
Сумын засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/01 дүгээр захирамжаар Засаг даргын газрын бүтэц орон тоог батлахдаа бүтэц орон тооны хязгаарыг хэтрүүлэн баталж гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтны 0.5 орон тоог баталж нийт 2,838.0 төгрөгийн цалинг олгосон, мөн төрийн захиргааны албан хаагч төрийн үйлчилгээний албан тушаал болох бичиг хэргийн ажлыг хавсран гүйцэтгэсэн нь санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.	1	2,838.00			1.0	2,838.00						
Засаг даргын нөөц хөрөнгөөс анхан шатны баримтгүй нийт 638.7 мянган төгрөгийг зарцуулсан нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1.0	638.7	1.0	638.7								
Үнэлгээний хорооны гишүүдэд урамшуулал олгосон нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1.0	1,050.00			1.0	1,050.00						
Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа холбогдох журмыг бүрэн баримтлан зарцуулаагүй байгаа нь санхүүгийн	1						1					

тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.												
2023 онд бараа материалын тооллогын үлдэгдлийг тоолж баталгаажуулсан байхад 2024 оны санхүүгийн тайланд 2023 оны малын зарлагыг илэрхийлсэн нь санхүүгийн тайлангийн аудитын тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1.0	1,686.00	1.0	1,686.00								
Дүн	6	6,212.70	2.0	2,324.70	2.0	3,888.00	2	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	0	0			0	0.0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /төрийн хэмнэлтийн тухай хууль/								
Жилийн эцэст байгууллагын ажилчдад төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж согтууруулах ундаа, бэлэг дурсгалын зүйлд төсвийн хөрөнгийг зарцуулсан санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1	864.2	1	864.2				
Дүн	1	864.2	1	864.2	-	-	-	-
Нийт дүн	1	864.2	1	864.2	-	-	0	0